

Монгол Улс
НЭЗХДШ-ТС-ийн баримт бичгийг боловсруулах хүрээнд Улаанбаатар хотын захиргааны
албан хаагчдаас санал авах уулзалт
2017 оны 9-р сарын 11

Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл ibaatarkhuu@worldbank.org и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.

Дэлхийн Банк Групп нь (ДБГ) Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодлоо солилцох зорилгоор 2017 оны 9-р сарын 11-ны өдөр Улаанбаатар хотын захирагчийн алба, хотын захиргааны агентлагуудын 15 төлөөлөлтэй уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p style="text-align: center;">Дүн шинжилгээний баримт бичигт тусгах санал (боломж, сорилт, тулгамдсан асуудал ба ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга замууд)</p>	<p><u>Боломж</u></p> <ul style="list-style-type: none">• 2016 оны УИХ-ын сонгуулийн дараа шинэ удирдлага хотын захиргааг хариуцан ажиллаж байна. Энэ үеэс хойш хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг хотын зөвлөл баталлаа.• Нийт хүн амын 60% нь Улаанбаатар хотод оршин суудаг.• Хэрэв хотод ажлын байр ихээр бий болгож чадвал илүү олон хүн орлогын албан татвар төлнө. Улаанбаатар хотод аж үйлдвэрийг хөгжүүлэх, гадаадад ажиллаж буй иргэдийн ур чадварыг ашиглах боломж, давуу тал их бий. <p><u>Сорилтууд</u></p> <p>Засаглал:</p> <ul style="list-style-type: none">• Засгийн газрын бүтэц зохион байгуулалт, төрийн байгууллагуудын бүтэц төвөгтэй болсон. Нийслэл хотын статус нь 20.000 хүн амтай аймгийн төвтэй ижил байгаа. <p>Хүнсний аюулгүй байдал:</p> <ul style="list-style-type: none">• Монгол улсыг хөдөө аж ахуйн орон гэлцдэг. Монголын эдийн засаг ч малаасаа хамаардаг. Гэвч хотын захын дүүрэгт малын өвчин гарсан нь хүнсний аюулгүй байдлын эрсдлийг үүсгэсэн. Ихэнх хүмүүс зах зээлээс боловсруулаагүй махыг худалдан авч хэрэглэдэг. Мах боловсруулах

технологи, хяналтын системийг сайжруулж, мах боловсруулах үйлдвэрлэлийн салбарт нэвтрүүлэх шаардлагатай.

Байгаль орчин ба хотын тогтвортой байдал:

- Орон сууц барьж байгуулах нь хотжилтыг хөтлөх гол хөдөлгөгч хүчин зүйл болох хандлагатай байна. Гэвч хотын соёл, суурин иргэншилд иргэдийг сургах, зан төлөв, хандлагын асуудал орхигдож байна.
- Усны хомсдол. УБ хотын усны хомсдол ноцтой асуудал болох хэмжээнд ойртож байна. Улаанбаатар хотын хүн амын 60% нь гэр хороололд амьдардаг. Гэр хорооллын нэг оршин суугч өдөрт дунджаар 8 литр ус хэрэглэдэг бол орон сууцанд амьдарч буй иргэн өдөрт дунджаар 250 литр ус хэрэглэдэг. Орон сууцтай иргэдийн тоо нэмэгдвэл нэг хүнд ногдох усны хэрэглээ өснө. Арьс шир боловсруулах үйлдвэрүүд үйлдвэрлэлийн хаягдал усаа Туул гол руу асгаж байна.
- Нүүрсийг үр ашиггүй ихээр түлэх буюу бусад хүчин зүйлийн улмаас (жишээ нь хөдөө аж ахуйн болон малын хог хаягдлыг шатаах, хот суурин газрын хүн амын хурдацтай өсөлт, тээврийн хэрэгслийн гэнэтийн өсөлт, цахилгаан станцуудын бохирдол зэрэг) агаарын бохирдол маш хүнд асуудал болж байна. Зарим судалгаагаар агаарын бохирдлын улмаас хотын ихэнх оршин суугчид ирэх 30 жилд уушигны өвчтэй болох магадлал өндөр байгааг харуулжээ. Хүүхдийн эрүүл мэндийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэх хэрэгтэй.
- Хөрсний бохирдол - Хот суурин газрын дэд бүтцийн хүртээмжгүйн улмаас гэр хорооллын айл өрхүүдээс гарах хаягдал ялгадсыг зохистой шийдээгүйгээс Улаанбаатар хотын хөрсний бохирдол үүсч байна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чиглэлээр бусад хандивлагч байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай. Цөлжилт, ой мод сүйтгэх явдал, бэлчээрийн доройтол зэрэг уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө Монгол улсад улам бүр нэмэгдэж байна.
- Тогтвортой хөгжлийн бодлого дутагдаж байна. Төрөөс уул уурхайн салбарыг тэргүүлэх чиглэл болгосон боловч байгаль орчны тогтвортой байдал хангалтгүй байна.

Ажилгүйдэл

- Ажилгүйдэл нь архидалт, хулгай дээрэм, бусад гэмт хэрэг зэрэг нийгмийн асуудлыг үүсгэж байна.
- Ажлын байр ихээр бий болгох өргөн боломжтой хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэх шаардлагатай.
- Бүтээмжийг нэмэгдүүлэх, хувийн хэвшлийн салбарын өсөлт, ажлын байр бий болгоход туслах зэргээр ЖДҮ-ийг дэмжих.

Аялал жуулчлал

- Аялал жуулчлалтай холбоотой урсгал нь ихэнх хөгжингүй орнуудад гадаад валютын арилжаа худалдааны гол эх үүсвэр байдаг. Иймд энэ боломжийг

судалж аялал жуулчлалын салбарын бүтээмжийг нэмэгдүүлэхэд туслах нь зүйтэй.

Боловсрол:

- Боловсролын чанарыг сайжруулах, салбарын шинэчлэл хийх шаардлагатай.
- Барилгын яам сургуулийн барилга байгууламж барихад анхаарлаа хандуулан, харин боловсролын чанарын асуудал орхигддог.
- Засгийн газрын агентлаг хоорондын уялдаа холбоо сул байгаа нь боловсролын салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна. Шинэ сургууль барих байршлын асуудлыг яам шийддэг. Барилгын хяналтын зардал ч мөн яаманд харъяалагддаг. УБ хотын захиргаа шинэ төслүүдийн чанар, үр ашгийг хянах боломжгүй.
- Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж хангалтгүй: Цэцэрлэгт хамрагдах сугалааны бүртгэлд 29000 хүүхэд бүртгүүлсэн байдаг. Гэвч 22000 хүүхдийг л цэцэрлэгт хамруулахаар болсон байна. Бусад хүүхдүүд гэртээ үлдэхээр болжээ.
- Сургуулийн байршил чанарт нөлөөлдөг. Жишээ нь 1-р дунд сургуульд олгодог боловсролын чанар хотын захын хороолол болох “7-н буудлын” сургуульд олгож буй боловсролын чанар ялгаатай.
- Залуучуудыг сурган хүмүүжүүлж, амьдралын туршлагаасаа хуваалцахад ахмад иргэдийг татан оролцуулах тогтолцоог бий болгох хэрэгтэй байна.

Хэт төвлөрөл:

- Олон улсын стандартын дагуу хот төлөвлөлтийн үр ашигтай, стратегитайгаар боловсруулах шаардлагатай байна.
- Хэт төвлөрлийн гол шалтгаан нь төрийн өмчийн их сургуулиуд Улаанбаатар хотод байрладагтай холбоотой. Иймд хэт төвлөрлийн асуудлыг шийдвэрлэхийн тулд их дээд сургуулиудыг хотоос гаргах нь зүйтэй.
- Худалдааны томоохон захууд замын хөдөлгөөний түгжрэл, хэт төвлөрлийн өөр нэг шалтгаан мөн. Иймд бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээ гэх мэт бизнесийн шинэ санааг бизнес эрхлэгчид бий болгох нь чухал юм.
- Дагуул хотын хөгжлийг дэмжих хэрэгтэй.

Дэд бүтцийн хөгжил:

- Дэд бүтэц хангалтгүй учраас хог хаягдлын менежмент муу, хотын цэвэр ус, ариун цэврийн нөхцөл байдал хангалтгүй зэрэг хүндрэлийг бий болгож байна.
- Нийтийн тээвэр – Замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах чиглэлээр олон нийттэй ажиллахад хотын захиргаа анхаарал хандуулж байгаа ч хангалтгүй хэвээр байна. Автобусны буудлууд нь оршин суугчдын дүүргээс хол байрладаг, автобус хуваарийн дагуу явдаггүй. Автобусанд жижиг гэмт хэрэг, дээрэм тонуул ихтэй зэрэг асуудал байсаар байна.

- Бохир ус цэвэрлэх байгууламжийн засвар үйлчилгээ - Хотын цэвэрлэх төв байгууламжийг өргөтгөж шинэчлэх шаардлагатай. Бохир усыг цэвэрлэсэн болоод Туул гол руу шууд асгаж байгаа нь байгаль орчин, бохирдлын асуудал үүсгэж байна. Цэвэрлэх байгууламжийн ойролцоо бүсэд голоос таагүй үнэр үнэртдэг. Энэ нь аялал жуулчлалын салбарын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Гамшгийн эрсдэлийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлт:

- Монгол улсад өвөлдөө зуд, зундаа үер, хээрийн түймэр тохиолдох нь элбэг учраас бэрхшээлтэй байдаг. Иймд гамшгийн эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь улс орны тэргүүлэх чиглэлүүдийн нэг юм.
- Онцгой байдлын үед улсын сургуулиуд эсвэл иргэдийн танхимыг ашиглах талаар сайтар төлөвлөж, удирдан зохион байгуулах хэрэгтэй. Япон улс энэ чиглэлээр их туршлага хуримтлуулсан бөгөөд үүнийг судлах боломжтой.

Эрчим хүч:

- Монгол Улс нар, салхи, ус, газрын гүний дулааны эрчим хүч гэх мэт сэргээгдэх эрчим хүчний томоохон эх үүсвэртэй. Ялангуяа Улаанбаатар хотод нарны эрчим хүчийг ашиглах боломж их юм. Иймд Монгол улсад сэргээгдэх эрчим хүчний салбарыг өргөжүүлэн хөгжүүлэх нь нэн чухал юм.

Бусад асуудал:

- Ахмад настангуудад илүү анхаарал халамж тавих хэрэгтэй. Ахмадуудад зориулсан шинэ төв барихын оронд сургуулийн спортын танхим зэргийг ахмадуудад зориулсан арга хэмжээ зохион байгуулахад ашиглах өөр арга зам бий.
- Монгол улс газар доорх уснаас ихээхэн хамааралтай. Гүний усыг хамгаалж зохистой удирдах хэрэгцээ шаардлага их бий.

<p>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаарх санал</p>	<ul style="list-style-type: none"> • Олон улсын ногоон санхүүжилтийн сан байгуулах боломж бий. Улаанбаатар хотыг уур амьсгалын өөрчлөлтөд илүү дасан зохицох, тэсвэртэй болоход туслах зорилго бүхий санхүүжилт авахад зохицуулан чиглүүлэх үүргийг ДБ гүйцэтгэх болох юм. • Хэдийгээр ДБ нь Монгол улсын гол санхүүжүүлэгч түнш боловч шинэ төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл авах үйл явц нь төвөгтэй, урт удаан хугацаатай байдаг. • УБ хотын Цэвэр Агаар төслийг сунгаж өргөжүүлэх, УБЦАТ-ийн төсөл хэрэгжүүлэх нэгжийг ашиглан агаарын бохирдлоос гадна хөрс, усны бохирдлын асуудлыг шийдвэрлэхэд туслалцаа үзүүлэхийг санал болгож байна. • Одоогийн тулгамдсан асуудал, сорилтуудыг хэрхэн боломж болгож даван туулах талаар зөвлөн туслах үйлчилгээг ДБ хотын захиргаанд үзүүлж чадна. • Хотын бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр ажиллах. Үндэсний үйлдвэрлэлийн 60 хувь нь хотод байдаг учраас УБ хотод ажилгүйдлийн түвшинг бууруулах боломжтой их бий. • Хотын санхүү, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулахад туслалцаа үзүүлэхийг санал болгож байна. • Гамшгийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах нь улс орны тэргүүлэх чиглэл учраас хотын захиргаатай хуваалцаж болох мэдлэг, туршлага ДБ-д бий. • Аналитик судалгаа шинжилгээний ажил хийх, олон улсын тэргүүн туршлагаас хуваалцах замаар тогтвортой хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх • УБ хотын хэт төвлөрлөөс зайлсхийх зорилгоор хот төлөвлөлтийг сайжруулах талаар зөвлөгөө өгөх • Бизнесийн орчныг сайжруулахын тулд ЖДҮ-ийн хөгжлийг дэмжих
--	--

Уулзалтын үеэр авсан судалгааны дүн:

1. Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хариултын сонголтууд–	Хариулсан байдал	
— Боловсрол	6	66.67%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	6	66.67%
— Төрийн удирдлага, засаглал/шинэтгэл	5	55.56%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	4	44.44%
— Хүнсний аюулгүй байдал	3	33.33%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	3	33.33%
— Гадаадын хөрөнгө оруулалт	2	22.22%
— Санхүүгийн зах зээл	2	22.22%
— Ус, ариун цэврийн байгууламж	2	22.22%
— Авилгатай тэмцэх	2	22.22%
— Хөдөөгийн хөгжил	2	22.22%
— Эдийн засгийн өсөлт	1	11.11%

— Эрүүл мэнд	1	11.11%
— Зам, тээвэр	1	11.11%
— Хотын хөгжил	1	11.11%
— Нийгмийн хамгаалал	1	11.11%
— Эрчим хүч	1	11.11%
— Байгалийн нөөцийн удирдлага	1	11.11%
— Уур амьсгалын өөрчлөлт	0	0.00%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	0	0.00%
— Эрх тэгш боломжоор хангах	0	0.00%
— Худалдаа, экспорт	0	0.00%
— Гамшгийн эрсдлийн удирдлага	0	0.00%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хариултын сонголтууд–	Хариулсан байдал	
— Хүний хөгжлийг дэмжих	6	66.67%
— Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	6	66.67%
— Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	5	55.56%
— Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	4	44.44%
— Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	3	33.33%
— Бүгд чухал	1	11.11%